энэ нөхцөл байдлыг тухай бүрийн оновчтой шийдвэрээр зохицуулж чадаагүйн улмаас улам бүр хүрээгээ тэлж цаашдаа олон нийтийг хамарсан эмх замбааргүй байдалд хүрдэг болох нь ажиглагдаж байна. Зөвхөн эмх замбараагүй байдал тухайн үед үүсээд ч зогсох бус харин ч улс орны дотоод зөрчил түүнийг хамрах хүрээ хэмжээнээс хальж дэлхий нийтийн анхаарлын төвд орж бүс нутгийн аюулгүй байдлын хэмжээнд хүрч олон сар жилээр үргэлжилсэн гамшигт байдлыг бий болгож байгаа улс орны жишээ баримт өнөөдөр бодитоор бий болоод байна.

Үүнийг дагаад онц хүнд гэмт хэргүүд олноор үйлдэгдэж улс орны гэмт хэргийн нөхцөл байдал хууль хяналтын байгууллагын бүрэн хяналтаас ч гарах аюултай юм. Ийм нөхцөлд гол төлөв террорист халдлага, хүн амь, дээрэм, хулгай, хүч хэрэглэсэн онц ноцтой гэмт хэргүүд олноор үйлдэгдээд зогсохгүй нийтийн дунд түгшүүрт байдал бий болох сөрөг үр дагавартай байдаг. Энэ бүхнийг тоочоод байвал олон нийтийн сэтгэлийг түгшээсэн, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан цаашлаад нийгмийн сэтгэлд зүйд хортойгоор нөлөөлөх хэмжээний гамшигт хор уршгууд бий болсон гээд олон жишээ баримтууд гарч ирнэ.

Тэгвэл энэ бүхнээс яаж урьдчилан сэргийлэх вэ? Ийм нөхцөл байдал үүссэн үед яах вэ? ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? гэсэн асуултууд хөврөн гарна.

Иймд дараах арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна. Үүнд:

1. Дээр дурьдсан аливаа хэлбэрийн зөрчил маргааны үед нийгмийн шинжтэй гамшигт байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх гол үйл ажиллагааны нэг хэлбэр нь олон нийтийн санаа бодлыг зөв удирдан чиглүүлэх явдал юм.
2. Гамшгийн үед үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаанд онцгой анхаарч гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдийн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж нөхцлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч, нутаг дэвсгэрийн хяналтыг сайжруулах нь чухал.
3. Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх аливаа улс төрийн хүчнүүдээс дээрхи нөхцөл байдал үүссэн буюу, үүссэх нөхцөл байдал бий болсон даруйд үндэсний эв нэгдлийг сахин хамгаалах, ийм нөхцөлд хамтран ажиллах эрх зүйн баримт бичгийг боловсруулан гаргах.
4. Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүссэн үед хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтран ажиллах хууль эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх зэрэг нь өнөөдөр нэн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зүй ёсоор тооцогдох болоод байна.

*ХСИС-ийн Ерөнхий эрдмийн сургуулийн*
*Албаны бэлтгэлийн тэнхимийн эрхлэгч,*
*цагдаагийн дэд хурандаа, докторант Б.Батжав*

## “ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ТУСГАЙ БЭЛТГЭЛ” СУРГАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

Аливаа улс орон өөрийн гэсэн хууль сахиулах мэргэжлийн чадварлаг цагдаагийн албатай байх нь түүнд алба хааж буй алба хаагчдын мэргэжлийн боловсрол, ур чадвар хандлагаас ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс орчин цагт

дэлхийн улс орнууд цагдаагийн алба хаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн бэлтгэлийг хангахад анхаарал хандуулж байгаа нь судлагаанаас ажиглагдаж байна. Нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийг даган гэмт хэрэг, зөрчлийн шинж аюултай, зохион байгуулалттай болж байгаагаас гадна цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, эрх чөлөөнд нь халдах тохиолдлууд цөөнгүй гарсаар байна. Тухайлбал: ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс хийсэн судалгаагаар 2013 онд төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх гэмт хэрэг 100 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 8 хэргээр буюу 2.0 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь гол төлөв төрийн алба хаагч 95 буюу 95,0 хувь, үүний дотроос цагдаагийн алба хаагч 53.0 хувийг эзэлж байна[1]. Сүүлийн жилүүдэд "тусгай бэлтгэл" гэх үгийг манай орны цагдаагийн байгууллагын албан хэрэгт хэрэглэдэг болсон боловч Монгол Улсын хэмжээнд нэгдсэн ойлголт байхгүй, нарийвчлан шинжлэх ухааны түвшинд судалж гаргасан онолын тодорхойлолт байхгүй байгаа нь судлагааны явцад ажиглагдаж байна. "Тусгай бэлтгэл" гэх үгийг гардан тулааны хичээл, тусгай хүчний хичээл, марш тактикийн тэмцээн гэх олон төрлийн ойлголтуудыг бий болгож байна. Иймээс цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн сургалтын мөн чанар, онолын үндсийг нарийвчлан авч судалж тодорхойлох үүднээс ойролцоо буюу ижил төрлийн сургалт явуулдаг өөрийн орны болон бусад орны цагдаагийн сургалт бэлтгэл, эрх зүйн акт, бусад бичиг баримтанд тусгай бэлтгэлийн талаар тусгасан байдлыг харьцуулан авч үзлээ.

"Тусгай бэлтгэл" гэдэг үгийг монгол үг зүйн үүднээс нь судалж үзэхэд Я.Цэвэлийн"Монгол хэлний товч тайлбар толь" номыг ашигласан ба уг номонд **"тусгай"** гэдэг үгийг "тусдаа, өөр[2]" гэсэн утгаар тайлбарласан бол **"бэлтгэл"** гэдэг үгийг "урьдчилан бэлдсэн, бэлтгэл ажил[3]" гэж тайлбарласан нь **"тусгайлан бэлтгэх** " гэсэн санааг илэрхийлж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нилээдгүй эрх зүйн актуудад галт зэвсэг,тусгай хэрэгсэл, мэх, албаны нохой гэх мэт хэллэгүүд байгаа нь албаны тусгай бэлтгэлтэй уялдаатай болох нь ажиглагдлаа. Мөн "Эрх зүйн зөрчил үйлдсэнтэй холбоотойгоор түүнийг үргэлжлэн гаргахгүй болгох, учирч болзошгүй аюулыг нэмэгдүүлэхгүй зайлуулах зорилготой төрийн захиргааны эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр хэрэглэж байгаа шууд албадах ажиллагааг захиргааны таслан зогсоох албадлага хэмээн ойлгож болно[4]. "Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх ажиллагааг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны таслан зогсох тусгай албадлага, бусдыг нь таслан зогсоох нийтлэг албадлага гэж үзнэ[5]" гэж тодорхойлсон нь цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн хамрах хүрээг ерөнхий байдлаар тусгажээ.

[1] ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. "Монгол улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал" УБ. 2013. 112 дах тал.
[2] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. 559 дах тал.
[3] Я.Цэвэл. Мөн тэнд. 121 дэх тал.
[4] Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ. 2006. 186 дах тал.
[5] Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ. 2000. 248 дах тал.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн албаны мэргэжлийн түвшиг тогтоох, үнэлж дүгнэх, үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн бичиг баримтууд гарч байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллага жил бүр алба хаагчийнхаа мэргэжлийн түвшинг тогтоох зорилгоор боловсруулж гаргасан Цагдаагийн мэргэжлийн зэргийн шалгалт авах журмын 3.5. дах хэсэгт тусгай шалгуур үзүүлэлтэнд доорх төрлөөр шалгалт авахаар тусгажээ.

1.Тээврийн хэрэгсэл жолоодох чадвар 10 оноо

2. Нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх чадвар 20 оноо

3. Галт зэвсэгтэй харьцах дадлага, чадвар 20 оноо

4. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх дадлага, чадвар 10 оноо

5. Урьдчилан төлөвлөгдөөгүй байдалд оновчтой шийдвэр гаргаж, хойшлуулшгүй ажиллагаа явуулах чадвар 20 оноо

6. Зэвсэггүйгээр бие хамгаалах ур чадвар 20 оноогоор тус тус дүгнэж мэргэжлийн зэрэг олгохоор заасан нь цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн сургалтын төрлийг заасан заалт гэж ойлгож болохоор байна[1].

Судлаач Д.Дашмягмар “Албаны тусгай бэлтгэлийн хичээлийн хэлбэр, зохион байгуулалт сургалт арга зүйн бүтцийн уялдаа холбоо” нь албаны тусгай бэлтгэлийн хичээлийн явцад сонсогчдод бие бялдрын зөв хөгжилт, бие хамгаалах урлагийн хөдөлгөөний шинэ чадвар, дадлыг олгоод зогсохгүй эр зоригийн хүмүүжил, бие бялдрын соёлыг эзэмшүүлнэ. Мөн хэрэг зөрчил гаргасан этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааны тактик, галт зэвсэг чадварлаг эзэмших, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэнэтийн халдлагаас урьдчилан сэргийлэх арга зүйд суралцуулна[2] гэсэн нь цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн онолын агуулгыг хөндсөн байна.

ОХУ-ын эрдэмтэн В.Я.Кикот, А.М.Столяренко нар цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийг **“Хууль сахиулах үйл ажиллагаа, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, сэжиг бүхий этгээдтэй харьцах ажиллагааны явцад алба хаагч (бүлгийн удирдагч)-ийн гаргасан оновчтой шийдвэрийг эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн түвшинд амжилттай биелүүлэх мэдлэг, дадлага, чадварын цогцыг хэлнэ[3].** гэсэн нь хэт ерөнхий тодорхойлолт гэж судлаачийн хувьд үзэж байна.

Мөн НҮБ-аас батлан гаргасан “Хууль сахиулах албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-ийн “Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчмууд“ гэсэн заалтанд ’’Мэргэшил, бэлтгэх ба зөвлөгөө” гэсэн хэсгийн 19-д Засгийн газар болон хууль хамгаалах байгууллага хэв журам сахиулах үүрэг бүхий бүх албан тушаалтанг хүч хэрэглэх үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, хүч хэрэглэх тусгай бэлтгэлийг нь шалгах нөхцлөөр хангана. Хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг

[1] Т.Сосорбарам. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ. 2008. 617 дах тал. ЦЕГ-ын даргын 2007.05.24-ны №218 тоот тушаал.

[2] Д.Дашмягмар. Албаны тусгай бэлтгэлжилтийг боловсронгүй болгох арга зүйн зарим асуудал. магистрын зэрэг горилсон дипломийн ажил. УБ. 2000.

[3] Прикладная юридическая педагогика в органах внутренних дел: учебник для курсантов и слушателей образовательнихучреждений МВД России юрид. профиля /под ред. В.Я.Кикот, А.М.Столяренко. - М., ЮНИТИ-ДАНА, 2008. С.270.

хэрэглэх талаар тусгай сургалтанд суралцаж төгссөний дараа галт зэвсгийг биедээ зохих зөвшөөрлийн дагуу авч явах ёстой[1]" гэж заасан байна. Тусгай бэлтгэлийн сургалтын талаар судлаачид янз бүрээр тодорхойлсон ч одоогоор нэгдсэн ойлголтонд хараахан хүрээгүй байна.

Манай орны цагдаагийн байгууллагын сургалт бэлтгэлийг судалж үзэхэд сургалтанд "тусгай бэлтгэл" гэж нэрлэгдсэн хичээл сургалт байхгүй байгаа бөгөөд "бие хамгаалах бэлтгэл " хичээлийн талаар гаргасан хэд хэдэн сургалтын ном, гарын авлагын нэрийг "албаны тусгай бэлтгэл", "албаны бэлтгэл" гэж нэрлэсэн байгаагаас гадна жил бүр зохион явуулдаг олон төрөлт тэмцээнийг "марш,тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн" гэж нэрлэж энэ талаар тушаал шийдвэр гарч уг тэмцээн зохион байгуулагдсаар иржээ.

"Тусгай бэлтгэл" нь практик шинжээрээ хүч хэрэглэх аргад сургах, алба хаагчдыг тэсвэр тэвчээр, хатуужилтай болгох, бие бялдарыг хөгжүүлэх, бусдыг аврах хамгаалах чиглэлээр тусгай бэлтгэл сургалт хийдэг бөгөөд онцгой тохиолдолд хуулийн хүрээнд уг мэдлэг чадвараа амьдралд ашигладаг нь тусгайлан авч үзэх үндэс болох юм.

Хэрэв тусгай бэлтгэл сургалтанд хамраагдаагүй бол гэмт этгээдтэй барьцалдаж авах, хөөж барих, ноцолдох, хол замд гүйх, саадыг давах , өндөрт авирах, бусдыг аврах үед та өөрөө бэртэж гэмтэхээс эхлээд бусдыг аварч чадахгүйд хүрч болзошгүй. Та аль болох бие хамгаалах болон спортоор байнга хичээллэх цагийг өөртөө гаргадаг байх хэрэгтэй. Мэргэшсэн цагдаагийн ажилтан байж ард иргэдэд тусламж үзүүлэх найдвар нэмэгдэж, хүмүүс ч таныг төдийгүй цагдаагийн алба хаагчдыг хүндэтгэж харьцах болно гэдгийг ямагт сана[2] гэж бичсэн нь тусгай бэлтгэлийн сургалтын ач холбогдолыг тодорхойлж байна. Цагдаагийн алба хаагч нь хуулиар хүлээсэн ажил, үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй тусгай мэдлэг, чадвар эзэмших шаардлагатай байдаг нь дээрхи нөхцлөөс ажиглагдаж байна. Улс орон болгон өөрийн орны эрүүгийн болон хэв журмын нөхцөл,байдлаас хамаарч тусгай бэлтгэлсургалтын төрөл агуулгыг шинэчлэн боловсруулаж цагдаагийн алба хаагчидаа сургаж бэлтгэж байна. Иймээс цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн тухай ойлголтыг монгол үг зүйн үндэс, эрдэмтэн, судлаачдын онол, эрх зүйн үндсийг харьцуулж дараах тодорхойлолтыг гаргаж байна.

**"Цагдаагийн алба хаагчнйн тусгай бэлтгэл" гэдэг нь цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүргээс хамаарч дотроо тусгайлсан мэргэшлийн хичээлүүдтэй, онцгой тохиолдолд бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг ажиллах, урьдчилсан бэлтгэл хангуулах зорилготой тусгай төлөвлөгөөгөөр явуулдаг бэлтгэл сургалтыг хэлнэ.**

Тухайлбал: Бие бялдрын хувьд хурдавчилсан хөдөлгөөн эзэмшүүлэх, саад туулах, мэргэн буудах, гардан тулалдаан хийх, усчлах, өндөрт авирах, гэх мэт ажиллагааг үйлдэхдээ нөхөддөө туслах дадлагыг эзэмших, тэсвэр хатуужилтай, хүч чадалтай, хөнгөн шаламгай байх зэрэг бие бялдрын сайн талын чанарыг байнга төгөлдөржүүлэн хөгжүүлэх, сэтгэл зүйн талаар тогтвортой, шийдэмгий, зоригтой,

[1] Хүний Эрхийн Дээд Комиссарын газар. Хүний эрхийн төв. ''Хүний эрх ба хууль сахиулах нь" УБ. 2005. 256 дах тал.

[2] Монголын Эмнести Интернэшил. "Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь" УБ.2007. 66 дах тал.

санаачилгатай, тэсвэр хатуужилтай шаргуу ажилладаг, биеэ эзэмддэг болгох, байгаль цаг агаарын ямарч нөхцөлд бие махбодийг чийрэгжүүлж, эрүүл мэндээ бэхжүүлдэг болгон сургах зэрэг сургалтаас гадна хуулиар оногдуулсан үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад мэдлэг чадварыг эзэмших бэлтгэлийг хамааруулж ойлгоно. "Цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэл" нь цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн сургалтын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд алба хаагчдыг сургаж, хүмүүжүүлэх ажлын салшгүй чухал хэсэг юмаа. Учир нь цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн сургалт нь багшлах бүрэлдэхүүнээс ур чадвар, арга зүй, сургалтын орчин болон сонсогчоос маш нарийн дэг журам, сахилга бат, зохион байгуулалт, сэтгэл зүйн бэлтгэл шаарддагаас гадна сургалтыг бодит нөхцөл байдалд ойртуулсан орчинд явуулах шаардлага тавигддаг ба тусгай техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнд тулгуурлан мэдлэг, чадвар дадал олгох бөгөөд бэлтгэл сургалтын 80%-ийг дадлагын хичээл эзэлдэг нь цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн сургалтын мон чанар, онцлог юмаа. Эдгээр онцлог шалгуур нь хувь хүнийг сургаж дадлагажуулахаас гадна ёс зүйг олгож байдгаараа бусад хичээл сургалтаас илүү практик ач холбогдолтой байдаг. Дээрх гаргасан онолын үндэст тулгуурлаж тусгай бэлтгэл сургалтыг дараах төрөлд ангилаж байна.

**Цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэл:**

Цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэл нь,удирдлагын, хүн нэг бүрийн, хэлтэс, тасаг, албаны бэлтгэлээс бүрдэнэ.

**1. Цагдаагийн удирдах ажилтаны тусгай бэлтгэл:**

Удирдлагын тусгай бэлтгэл нь онол, хээрийн сургуулийн хэлбэрээр зохион байгуулагдаж, хүч хэрэглэх үйл ажиллагааг хууль зүйн хүрээнд удирдах арга,зохин байгуулах, багаар ажиллах ур чадварыг эзэмшүүлэх, гар нийлэмжтэй ажиллагааг хангах, харилцан ажиллагааг сайжруулахад чиглэгдэх бөгөөд газар, хэлтсийн (алба) жигдэрэлтийг хангах сургалт гэсэн ангилалтай байна. Хүн нэг бүрийн бэлтгэл нь онолын болон дадлагын хэлбэртэй байх ба офицер, ахлагч гэж ангилан дараах бэлтгэл сургалтыг зохион байгуулана.

**2. Алба хаагчийн нэг бүрийн тусгай бэлтгэл:** Цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай бэлтгэлийн сургалтыг дотор нь 3 ангилна.

**А. Цагдаагийн анхан шатны тусгай бэлтгэлийн сургалт:**

Анхан шатны тусгай бэлтгэлийн сургалт нь цагдаагийн албанд шинээр орж байгаа хүмүүст заагдах бэлтгэл сургалтыг ойлгох ба мэргэжлийн суурь мэдлэг дадлага,чадвар олгоход чиглэгдэнэ.

**Анхан шатны тусгай бэлтгэлээр дараах сургалт бэлтгэл хнйгдэнэ.**

1. Бие бялдрын бэлтгэл
2. Бие хамгаалах тактик
3. олбооны бэлтгэл
4. Амьд үлдэх бэлтгэл
5. Галт зэвсгийн бэлтгэл
6. Усны бэлтгэл
7. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бэлтгэл
8. Албаны морь, нохой сургах бэлтгэл
9. Тээврийн хэрэгсэл жолоодох бэлтгэл

**Б. Цагдаагийн алба хаагчдын дунд шатны тусгай бэлтгэлийн сургалт:**

Цагдаагийн алба хаагчийн дунд шатны тусгай бэлтгэлийн сургалт нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгэмийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг бүхий офицер бүрэлдэхүүнд заагдана.

**Дунд шатны тусгай бэлтгэлээр дараах сургалт бэлтгэл хнийгдэнэ.**

1. Бие бялдрын бэлтгэл
2. Бие хамгаалах тактик
3. Холбооны бэлтгэл
4. Амьд үлдэх арга
5. Галт зэвсгийн бэлтгэл
6. Усны бэлтгэл
7. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх бэлтгэл зэрэг байна.

**3. Цагдаагийн алба хаагчийн гүнзгнйрүүлсэн тусгай бэлтгэлийн сургалт:**

Гүнзгийрүүлсэн тусгай бэлтгэлийн сургалт нь тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад заагдах бэлтгэл сургалтыг ойлгоно. Цагдаагийн алба хаагчийн гүнзгийрүүлсэн тусгай бэлтгэл нь анхан шатны, дунд шатны бэлтгэл сургуулилтанд тулгуурлан бие бүрэлдэхүүнийг биеийн хүч хэрэглэх ,галт зэвсэг эзэмших, тусгай хэрэгсэл, техникийг чадварлаг ашиглаж сургах, алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, бусад төрлийн ажилтнуудтай уялдаатай ажиллах бэлтгэлийг хангуулах, тусгай ажиллагааны тактикийн дадлага,чадварыг дээшлүүлэх. Энэ бэлтгэлийн үед янз бүрийн хэлбэрийн сургалтыг явуулна. Тэдгээрээс гол сургалтууд нь тусгай тактикийн бэлтгэл, хээрийн сургалт гэсэн сургалт бэлтгэлийг хамруулна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*цагдаагийн хошууч Б. Сүхбат*

## ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Өнөө үед хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдал, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд аюул учруулахуйц аюулт үзэгдэл, гамшгийн тоо харьцангуй нэмэгдэж, түүнээс учрах хор уршгийн үр дагавар улам бүр нэмэгдэж, үүссэн онцгой нөхцөл байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд ердийн арга хэрэгслээр хэвийн байдалд оруулах боломжгүй нөхцөл байдал бий болсоор байгаа ба энэхүү аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг удирдан зохион байгуулахыг Монгол Улс өөрийн эдийн засаг, нийгэм, үндэсний аюулгүй байдлын алс хэтийн бодлогодоо тусгах цаг аль хэдийн болсон байна.

Онцгой нөхцөл байдал гэж Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдал, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд шууд аюул учруулхуйц байдал үүсч түүнийг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд ердийн арга хэрэгслээр хэвийн